

Улсын бүртгэлийн
дугаар
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл Энгийн
Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар:
ШуАГ- 2020/03

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

“АКАДЕМИЧ ЧУЛУУНЫ ДАЛАЙ: АМЬДРАЛ, ҮЙЛС, ЭРДМИЙН ӨВ”

ШУА-ИЙН ГРАНТ ТӨСЛИЙН ТАЙЛАН

2020-2021

Төслийн гүйцэтгэгч байгууллага:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн
Төслийн удирдагч:	Р.Төрдалай, доктор (Ph.D), ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Гарын үсэг:
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан, технологийн сан
Захиалагч байгууллага:	Шинжлэх Ухааны Академи
Тайланг өмчлөгч байгууллага:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн ШУА-ийн хүрээлэнгүүдийн II байр, Баруун Сэлбэ-15, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Улаанбаатар

2022 он

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

“АКАДЕМИЧ ЧУЛУУНЫ ДАЛАЙ: АМЬДРАЛ, ҮЙЛС, ЭРДМИЙН ӨВ”

СЭДЭВТ СУУРЬ, ХАВСАРГА СУДАЛГААНЫ ГРАНТААР ГҮЙЦЭТГЭСЭН
ТӨСЛИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР

2022 он

**СУУРЬ, ХАВСАРГА СУДАЛГААНЫ ГРАНТААР ГҮЙЦЭТГЭХ
ТӨСЛИЙН КАРТ**

Улсын бүртгэлийн дугаар	Нууцын зэрэглэл энгийн
Кодын дугаар	Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар ШуАГ- 2020/03
Төслийн гүйцэтгэгчийн нэр:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн
Төслийн тайлангийн бүрэн нэр:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал асан, академич, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Чулууны Далайн 90 насны ойд зориулан хэрэгжүүлсэн “Академич Чулууны Далай: Амьдрал, үйлс, эрдмийн өв” сэдэвт бүтээл хэвлүүлэх суурь, хавсарга судалгааны грантаар гүйцэтгэсэн төслийн тайлан
Тайлангийн төрөл:	Эцсийн тайлан
Төслийг хэрэгжүүлсэн хугацаа:	2020-2021 он
Төслийн удирдагч:	Р.Төрдалай, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)
Иргэний регистрийн дугаар:	АЮ80122490
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан, технологийн сан
Төслийн захиалагч байгууллага:	БШУЯ, ШУА
Тайланг өмчлөгч байгууллага:	ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн
Төслийн гүйцэтгэгчийн шуудангийн хайрцаг:	Р.О.В-187, Улаанбаатар-38, Монгол Улс, 15141, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн Утас: 976-11-317185, 70007185 Факс: 976-11-322613 Email: iis@mas.ac.mn , turdalair@mas.ac.mn
Төсөл гүйцэтгэсэн хот:	Улаанбаатар
Тайлан бичсэн он:	2022 оны 11 дүгээр сар

РЕФЕРАТ

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн тэгш ой 2020 онд тохиосон билээ..

Ч.Далай нь багш, эрдэм шинжилгээний ажилтнаас эрдмийн гараагаа эхлүүлж, улмаар 1968 онд ШУА-ийн дэргэд Ази, Африк судлалын хэлтэс байгуулагдах үеэс хэлтсийн дарга, салбарын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирлын албанаа тус тус томилогдон ажилласан байна.

Тэр бээр Монгол Улсын боловсрол, шинжлэх ухаан, дипломат албанаа нэгэн жарны хугацаанд хүчин зүтгэж ажиллахдаа Монголын түүхийн бараг бүхий л үеийг хамарсан өргөн цар хүрээтэй сэдвээр судалгаа хийж, манай улсад Дорно дахин судлал, тухайлан Зүүн хойд Ази судлалыг хөгжүүлэх, тодорхой чиглэл, үзэл баримтлалыг бий болгох, шинэ боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдмийн хамт олныг бүрэлдүүлэн төлөвшүүлэх үйлсэд бодитой хувь нэмрээ оруулжээ.

Академич Ч.Далай нь Монголын түүхийн судалгааны хэд хэдэн чиглэлээр илүүтэй анхааран судалж, өөрийн үзэл номлол, байр суурийг дэвшүүлэн гаргасан байдаг. Үүнд, Хамаг Монгол, Их Монгол, Монголын Эзэнт гүрэн, Чингис хааны төрийн бодлого, үйлс замналын тухай, Монголын угсаатан үүсэж бүрэлдсэн түүх ба төрт ёсны уламжлал, шашин, соёл, Монгол, Төв Азийн соёл иргэншил, үндэсний сэргэн мандлын тухай, Монгол-Хятад, Монгол-Япон, Монгол-Солонгосын түүхэн харилцааны тухай зэрэг өргөн хүрээтэй чиглэлийг хамарчээ.

Ч.Далайн нь эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл 20 гаруй, хамтын бүтээл 10 гаруй, хянан нягталсан ном, товхимол 20 орчим, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 250 гаруйг гадаад, дотоодод нийтлүүлсэн байдаг.

Шинжлэх ухааны байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, судалгааны олон арван бүтээл туурвиж, эрдэм судлалын залуу халааг бэлтгэх, Монгол Улсад орон судлал, гадаад харилцааны эрдэм шинжилгээний байгууллагыг бэхжүүлэхэд оруулсан Ч.Далайн бодитой хувь нэмрийг үнэлэн 1991 онд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, 1996 онд Монгол Улсын “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цолыг хүртээсэн байна. Тэрээр 1993 онд Монгол Улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн (Академич)-ээр сонгогдсон юм.

Иймд, академич Ч.Далайн мэндэлсний 90 жилийн ой 2020 онд тохиосонтой холбогдуулан ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 5 тоот тогтоолоор түүний эрдэм шинжилгээний бүтээлийн талаарх судалгааг хийж, тухайлсан бүтээл гарган сурталчлах зорилгоор “Академич Чулууны Далай: Амьдрал үйлс, эрдмийн өв” грант төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзсэн болно.

I. Грантын зорилго

Энэхүү грант төслийн хүрээнд академич Чулууны Далайн эрдэм судлалын бүтээлийг судлах, сурталчлах, тухайлсан бүтээлийг хэвлүүлэн олон нийтэд хүргэх нь Монгол Улсын орон судлал, түүх, гадаад бодлогын суурь судалгааны хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм.

Өөрөөр хэлбэл, “Академич Чулууны Далай: Амьдрал үйлс, эрдмийн өв” грант төслийн хүрээнд их эрдэмтэн Ч.Далайн амьдрал үйлсийг намтар судлалын хүрээнд судлах, залуу хойч үед сурталчлах ажлыг зохион байгуулах нь эрдэм судлалын төдийгүй бүх шатны сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаанд холбогдох цаг үеэ олсон ажил болсон билээ.

Грант төслийн дэмжлэгтэйгээр тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас академич Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ойн хүрээнд түүний амьдрал үйлс, эрдэм судлалын өвийг сурталчилсан бүтээлийг нийтлүүлж, тус хүрээлэнгийн ахмад үеийн нэрт эрдэмтдийн бүтээлийн цувралын эхлэлийг тавих, эрдэмтэн судлаачид болон өргөн олны хүртээл болгохыг төслийн үндсэн зорилгоор тодорхойлж, үр дүндээ хүрсэн болно

II. Грантаас гарсан бодит үр дүн:

1. *Эрдмийн Далай*, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, 2020, 280 тал.
2. *Ч.Далай-90: Түүх судлалын асуудлууд*, Улаанбаатар, 2020, 180 тал.

IV. Түлхүүр үг: Академич Ч.Далай, амьдрал, үйлс, эрдмийн өв, судалгаа, дурсамж

V. Грант хэрэгжүүлсэн баг:

Грантын удирдагч.	Р.Төрдалай, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)
Гишүүд:	Д.Золбоо, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), профессор Л.Хайсандай, ШУГЗ, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор Ш.Догмийчойдон, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хятад судлалын салбарын ЭША, магистр

VI. Грант төслийн үр дүнгийн тайлан

1. Академич Чулууны Далайн намтрын өлгөц

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ой 2020 онд тохиов. Энэ хүрээнд их эрдэмтний эрдэм судлал, амьдрал үйлсийг тодотгон судлах, олон түмэнд сурталчлан түгээх чиглэлээр санал санаачилгууд өрнөсөн билээ.

Академич Ч.Далайн амьдралынхаа бүхий л цаг хугацааг зориулан зүтгэж ажилласан эрдмийн өргөө болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн дэмжиж 14 тоот тогтоол гаргаснаар академичийн эрдэм судлалын 9 ботийг Монгол судлалын Үндэсний зөвлөлийн дэмжлэгтэйгээр “Монгол судлалын шилдэг өв” цувралд анх удаа цогцоор нь эмхэтгэн нийтлүүлэх, “Олон улс судлал-2020” эрдэм шинжилгээний хурлыг Ч.Далайн нэрэмжит болгон Хятад орон судлалын чиглэлээр дагнан зохион байгуулахаар шийдвэрлэж, энэхүү хүндтэй бөгөөд хариуцлагатай ажил амжилттай хэрэгжих үндэс тавигдсан.

Үүнээс нэгэн чухал онцлох ажил нь академичийн эрдэм шинжилгээний бүтээлийн талаарх судалгааг хийж, тухайлсан бүтээл гарган сурталчлах зорилгоор “Академич Чулууны Далай: Амьдрал үйлс, эрдмийн өв” грант төслийг хэрэгжүүлсэн явдал болно.

Ч.Далай нь багш, эрдэм шинжилгээний ажилтнаас эрдмийн гараагаа эхлүүлж, улмаар 1968 онд ШУА-ийн дэргэд Ази, Африк судлалын хэлтэс байгуулагдах үеэс хэлтсийн дарга, ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн салбарын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, хожмоо Зүүн хойд Ази судлалын төв, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэнгийн захирлын албанаа тус тус томилогдон ажиллаж байв.

Тэр бээр Монгол Улсын боловсрол, шинжлэх ухаан, дипломат албанд нэгэн жарны хугацаанд хүчин зүтгэж, Монголын түүхийн бараг бүхий л үеийг хамарсан өргөн цар хүрээтэй сэдвээр судалгаа хийн Монгол улсад Дорно дахин судлал, тухайлан Зүүн хойд Ази судлалыг хөгжүүлэх, тодорхой чиглэл, үзэл баримтлалыг бий болгох, шинэ боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдмийн хамт олныг бүрэлдүүлэн төлөвшүүлэх үйлсэд бодитой хувь нэмрээ оруулсан байна.

Академич Чулууны Далай нь Монголын түүх судлалын олон арван бүтээлийг туурвин дотоод, гадаадад танигдсан нэрт түүхч эрдэмтэн байснаас гадна эрдмийн ажлыг чадамгай удирдан зохион байгуулагч, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, шавь нартаа өөрийн үзэл баримтлал, дэг сургуулийг өвлүүлэн үлдээсэн их багш, Монгол Улсын гадаад харилцааны салбарт хүчин зүтгэж явсан ахмад дипломатч байсан билээ.

Ч.Далай нь Монголын түүхийн судалгааны хэд хэдэн чиглэлээр илүүтэй анхааран судалж, өөрийн үзэл номлол, байр суурийг дэвшүүлэн гаргасан байдаг. Үүнд, Хамаг Монгол, Их Монгол, Монголын Эзэнт гүрэн, Чингис хааны төрийн бодлого, үйлс замналын тухай, Монголын угсаатан үүсэж бүрэлдсэн түүх ба төрт ёсны уламжлал, шашин, соёл, Монгол, Төв Азийн соёл иргэншил, үндэсний сэргэн мандлын тухай, Монгол-Хятад, Монгол-Япон, Монгол-Солонгосын түүхэн харилцааны тухай зэрэг өргөн хүрээтэй чиглэл багтаж байна.

Тэр бээр эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл 20 гаруй, хамтын бүтээл 10 гаруй, хянан нягталсан ном, товхимол 20 орчим, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 250 гаруйг гадаад, дотоодод нийтлүүлжээ.

Шинжлэх ухааны байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, судалгааны олон арван бүтээл туурвиж, эрдэм судлалын залуу халааг бэлтгэх, Монгол Улсад орон судлал,

гадаад харилцааны эрдэм шинжилгээний байгууллагыг бэхжүүлэхэд оруулсан Ч.Далайн бодитой хувь нэмрийг үнэлэн 1991 онд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, 1996 онд Монгол Улсын “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цолыг хүртээсэн байна. Тэрээр 1993 онд Монгол Улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн (Академич)-ээр сонгогдсон юм.

Гэвч их эрдэмтний амьдрал үйлсийн замнал шулуун дардан байсангүй. Тэр бээр 1970-1980-аад онд марксист-ленинист онолын мэдлэггүй, өөрийн зохиол бүтээлд энэхүү онол сургаалыг үзэл санааг тусгадаггүй, зөвхөн маоист үзэл сургаалд автагдсан” гэх мэтийн гүтгэлэг, хардлага сэрдлэгэд өртөж, албан ажлаасаа хэсэг зуур халагдаж, байцаагдаж, зохиол бүтээлээ хураалгаж, хэвлэн нийтлүүлэхээ хориулж, тэр ч байтугай галдан шатаалгаж, 10 шахам жилийн турш гадагш хил нэвтрэх эрхээ хасуулж байсан хатуу шийтгэл, харамсам гашуун үйл явдалтай учирч байсан удаатай.


Даравч дардайна, булавч бултайна гэгчээр их эрдэмтний бүтээл туурвилууд он цаг улиран одох бүр үнэ цэнэ нь улам нэмэгдэн тодорсоор байна. Бидний грантын хүрээнд эмхэтгэн нийтлүүлж буй 2 бүтээлээс харахад түүний шинжлэх ухааны аливаа ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэхэд баримталдаг нарийн арга барил, түүхийн эх сурвалж, архивын баримт сурвалжийг өргөн хүрээнд бүтээлчээр ашигладаг байдал, шинэлэг санал дүгнэлтүүд гаргадаг шинж чанар, Монголын түүхийн шинжлэх ухааны байр суурийг хамгаалан бэхжүүлэх чин эрмэлзэл, ухаалаг хандлага зонхилж, эх оронч сэтгэлгээ нэвт шингэсэн байгаа нь мэдрэгддэг билээ.

Ч.Далай багш нэгэнтээ “Монголчууд бид түүхэндээ хүчирхэг улс гүрэн ч болж явсан, бага буурайн туйлд ч хүрч үзсэн. Хойшид ч гэсэн буурайн туйл руу явахгүй гэх баталгаагүй. Гагцхүү монголчууд бидний өөрсдийн маань ухаан бодол, үйл хөдлөл, хувь тавилангаас л шалтгаална. Эх түүхээ дээдлэхгүй, мэдэхгүйгээр улс орноо удирдан залж, ирээдүйг заах тун хэцүү. Улс үндэстнийхээ түүхийг дутуу хагас мэдэх, тэр тусмаа түүхийг санааны зоргоор гуйвуулах шиг аюултай нүгэл хаа ч байхгүй” хэмээн сургамжлан захиж бичиглэн үлдээсэн нь өнөөгийн болоод ирээдүйн монголчууддаа хандсан гүн билигт сургаал болж үлджээ.

2. Грантын хүрээнд хэвлэгдсэн бүтээлүүдийн агуулга, үр дүн

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас академич Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ойн хүрээнд түүний эрдэм шинжилгээний


бүтээлийн талаарх судалгааг хийж, тухайлсан бүтээл гарган сурталчлах зорилгоор “Академич Чулууны Далай: Амьдрал үйлс, эрдмийн өв” грант төслийг хэрэгжүүлж, тус хүрээлэнгийн ахмад үеийн нэрт эрдэмтдийн бүтээлийн цувралын эхлэлийг тавих, эрдэмтэн судлаачид болон өргөн олны хүртээл болгохыг зорин ажилласан болно.



Эрдмийн Далай, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, 2020, 280 тал.

Энэхүү бүтээлдээ бид академич Чулууны Далайн эрдэм судлал, амьдрал үйлсэд холбогдох 60 орчим хүний дурсамжийг цуглуулан авч эмхэтгэсэн бөгөөд Монгол Улсын 30, ОХУ-ын 3, БНХАУ-ын 5, Японы 6, Тайваний 1 эрдэмтний дурсамжийг тус тус багтаасан болно. Дурсамж, аман түүхийн уг бүтээл нь хүрээлэнгээр овоглосон эрдэмтдийн амьдрал, үйлсийн судалгааг жишиг болгон цаашид хэрэгжүүлэх эхлэл болсон гэж үзэж байна.

Энэ хүрээнд Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зэрэг сумын удирдлагатай хамтран эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, эмхэтгэлийг хэвлүүлснээс гадна Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас их эрдэмтний мэндэлсэн нутаг Ховд аймгийн Зэрэг сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийг “Чулууны Далайн нэрэмжит болгох” шийдвэрийг гаргасан билээ.



Ч.Далай-90: Түүх судлалын асуудлууд, *Bibliotheca Oiratica*, CV, Улаанбаатар, 2020, 180 тал.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судалгааны багаас Тод номын гэрэл төв, Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Ч.Далай-90: Түүх судлалын асуудлууд” эрдэм шинжилгээний хурлыг Ховд аймагт зохион байгуулсан. Уг хурлаар академич Чулууны Далайн шинжлэх ухаан, судалгааны үйлс, эрдэм бүтээлийн судалгаа, ялангуяа Ойрадын түүх, соёлын судалгааны чиглэлээр 17 илтгэл хэлэлцсэн болно. Эмхэтгэлийг “Bibliotheca Oiratica” цувралын 105 дугаар боть болгон 2020 онд багтаан хэвлүүлэн гаргасан.

Академич Ч.Далайн бичгийн өв сан нь Монгол Улсын Үндэсний Төв Архив, Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны Төв архив, Үндэсний номын сан, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн архив, ШУА-ийн Түүх, угсаатны хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төвд голлон хадгалагдаж байгаа бөгөөд нэлээд гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүн нь түүний шавь нар, үр хүүхдүүд, “Алтайн Далай сан” ТББ-д байна.

Мөн энэ дашрамд дурдахад ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Чулууны Далайн мэндэлсний 90 жилийн ойд зориулан түүний эрдэм судлалын 9 боть цогц бүтээлийг анх удаа эмхэтгэн гаргаж, энэхүү нүсэр ажил олны байгууллага, эрдэмтэн судлаачдын хамтын хүчин чармайлтаар амжилттай хэрэгжсэн болно. Энэ дашрамд энэхүү грант төслийг дэмжин ажилласан ШУА-ийн удирдлага, ШУТС-ийн хамт олон, ШУА-ийн Нийгмийн ухааны Бага чуулганы Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор А.Амарсанаа, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдмийн хамт олондоо баярлаж талархсанаа илэрхийлж байна.

Дүгнэлт

Монгол Улсад гадаад орон судлал, гадаад бодлого, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн туулсан хагас зуун илүү жилийн эрдэм судлалын үйлс, бүтээсэн өвийг өнөөдөр эргэн харахад Монгол Улсын хөгжлийн суурь асуудал, оршин тогтнохуйн бодит баталгаа болсон гадаад орчин, түүний хувьсал өөрчлөлт, нөлөөлөл, үр дүн, түүх, үр дагаврыг шинжлэх ухаанч байдлаар нэгтгэн дүгнэх, төр засгийн байгууллагуудыг зөвлөмж, судалгаа, мэдээллээр хангах үүргээ биелүүлсээр иржээ. Хүрээлэнгийн энэхүү туулсан 50 гаруй жилийн түүхэн хугацааны дийлэнх хэсэг нь академич Чулууны Далай агсны эрдэм судлалын ажил үйлстэй нягт холбогдож байна.

Энэхүү төслийн хүрээнд хэвлэгдсэн бүтээлүүдийн шинэлэг тал нь ахмад болон залуу үеийн амьд холбоог бататгах, академич Ч.Далайн амьдрал үйлс, эрдэм судлалын өв, залгамж холбоо, Монгол Улсын шинжлэх ухаанд оруулсан бодит хувь нэмрийг цогц байдлаар гарган сурталчлах өргөн боломжийг нээсэнд оршиж байна.

Учир нь академич Чулууны Далайн Монголын түүх, орон судлал, гадаад харилцааны талаар дэвшүүлсэн санал, зөвлөмж, эрдэм шинжилгээний үнэлэлт дүгнэлт нь өнөө хэр ач холбогдлоо алдаагүй бөгөөд дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдаас өндөр үнэлгээ авч, Монгол Улсын түүх, нийгмийн шинжлэх ухаанд бодитой хувь нэмрээ оруулсаар байгаа билээ.

ШУА-ийн “ШУАГ-2019/10” тоот грант төслийн хүрээнд хэвлэгдсэн *Эрдмийн Далай, Ч.Далай-90: Түүх судлалын асуудлууд* хэмээх хоёр бүтээл нь академич Ч.Далайн амьдрал үйлс, эрдэм судлалын өвийг эрдэм шинжилгээний ба аман түүхийн эх сурвалжаар шинэчлэн баяжуулж, академичийн намтар, бүтээлийн судалгаанд зохих хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

Энэхүү грант төсөл хэрэгжсэнээр цаашид хүрээлэнгийн ахмад үеийн нэрт эрдэмтдийн судалгааг цогц байдлаар гарган олон нийтэд сурталчлах, эрдэм шинжилгээний тусгайлсан сан хөмрөг бүрдүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн гэж дүгнэж байна.

Тайлан бичсэн:

Грант төслийн удирдагч, доктор (Ph.D) Раднаасэдийн ТӨРДАЛАЙ